



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 08 сарын 23 өдөр

Дугаар А/51

Улаанбаатар хот

Хэлэлцүүлэг зохион байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Донорын тухай хуулийн 21 дүгээр зүйл, Хууль тогтоомжийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалт, Улсын их хурлын 2021 оны 12 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/132 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын баталсан 2022 оны 4 сарын 21-ний өдрийн Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтээр зохион байгуулах хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагааны удирдамж, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан 2022 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн төсвийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Цусны донорын тухай анхдагч хуулийн төслийн хэлэлцүүлэг зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Цусны донорын тухай анхдагч хуулийн төслийн хэлэлцүүлэг хийх, хуулийн төсөл боловсруулах арга хэмжээг зохион байгуулж, тайланг Удирдлагын зөвлөлд танилцуулахыг Ажлын хэсэг /Н.Эрдэнэбаяр/-т даалгасугай.

3. Хэлэлцүүлэгт шаардагдах зардлыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан 2022 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн төсвөөс санхүүжүүлэхийг Санхүү, бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч /Х.Одгэрэл/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нарийн бичгийн дарга, Хүний нөөцийн ажилтан, хуулийн зөвлөх /Я.Тогтохням/-д үүрэг болгосугай.


ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР

080241

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
2022 оны 28 дугаар сарын 23-ны өдрийн
А/5/ дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



ЦУСНЫ ДОНОРЫН ТУХАЙ АНХДАГЧ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

- Н.Эрдэнэбаяр /Ерөнхий захирал/


Гишүүд:

- Ч.Батболд /Захиргаа, маркетингийн албаны дарга/
- Б.Солонго /Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн албаны дарга/
- Ч.Тунгалаг /Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч/
- Н.Халиун /Үйлдвэрлэлийн тасгийн эрхлэгч/
- М.Цэрэндэжид /Нэгдсэн лабораторийн тасгийн эрхлэгч/
- Х.Одгэрэл /Санхүү, бүртгэлийн албаны дарга/

Нарийн бичгийн дарга:

- Я.Тогтохням /Хүний нөөцийн ажилтан, хуулийн зөвлөх/
- А.Түвшин /Архив, бичиг хэргийн эрхлэгч/

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
2022 оны 18 дугаар сарын 23-ны өдрийн
А/51 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



ЦУСНЫ ДОНОРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийж гүйцэтгэх ажил	Хариуцах эзэн	Хугацаа	Тайлбар
Нэг. Зохион байгуулалтын ажлын талаар				
1	Ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах	Ажлын хэсгийн дарга	2022.09.01	
2	Ажлын хэсгийн гишүүдэд Цусны донорын тухай хуулийг боловсруулах үндэслэл, зохицуулах харилцаа, цус сэлбэлт судлалын салбарын өнөөгийн байдлын талаар танилцуулга хийх	ЦССҮТ-ийн Ерөнхий захирал	2022.09.05	
3	Хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэг зохион байгуулахад шаардагдах төсвийн төсөл боловсруулах ажил зохион байгуулах	Ажлын хэсгийн дарга ЦССҮТ ДЭМБ	2022.09.05- 2022.09.09	
Хоёр: Хуулийн төслийн хэлэлцүүлэг хийх бэлтгэл ажлын талаар				
1	Гадаад улсуудын Цусны донорын тухай хуулийн судалгааг нэгтгэх	ЦССҮТ	2022.09.01- 2022.09.05	
2	Цусны донорын талаар хийсэн судалгааны материалыг цуглуулах	ЦССҮТ	2022.09.12- 2022.09.16	

3	Цусны салбар төвийн ажилтнуудыг оролцуулсан семинарын хүрээнд хуулийн төсөлд оруулах саналыг тандах, судалгаа авах	Ажлын хэсэг ЦССҮТ	2022.09.19- 2022.09.23	
4	Эмнэлгийн мэргэжилтнүүдийг оролцуулсан хэлэлцүүлгийн материал бэлдэх	Ажлын хэсэг	2022.09.22	
5	Цусны доноруудыг оролцуулсан хэлэлцүүлгийн материал бэлдэх	Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга	2022.09.23	
Гурав. Хэлэлцүүлэг хийх				
1	Холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг хийх	Ажлын хэсэг	2022.09.25	
2	Эмнэлгийн мэргэжилтнүүдийг оролцуулсан хэлэлцүүлэг хийх	Ажлын хэсэг	2022.09.26	
3	Цусны доноруудыг оролцуулсан хэлэлцүүлэг хийх	Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга	2022.09.24	
4	Саналыг нэгтгэж, ажлын хэсгийн хурлаар хэлэлцэх	Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Ажлын хэсэг	2022.09.30	
Дөрөв: Бусад ажлын талаар				
1	Хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх хийхэд	Ажлын хэсэг	2022.09.01- 2022.09.05	

	шаардлагатай төсвийн төсөл боловсруулах			
2	Төсвийн зарцуулалтийн тайланг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагад хүргүүлэх	Ажлын хэсэг	2022.10.05	